



УЯНГА СУМЫН
АРДЧИЛСАН НАМ-Д

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020. 07. 28 № 218.
танай _____ -ны № _____ -т

Хандивын тайлангийн дүгнэлт

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Ардчилсан нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Тухайн намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулаагүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/47 тоот тушаалаар батлагдсан


зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно

Дүгнэлт

УЯНГА СУМЫН АРДЧИЛСАН НАМ нь 2020 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

“Сумын Ардчилсан нам”-аас ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт..... хуудастай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Л.ЛАМААЧИН

МАЯГТ-2

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын согуульд оролцох
нам, эвсэлд "ХУУЛИЙН ЭТГЭЭД"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт

/Уянга сумын Ардчилсан нам/

/МЯН.ТӨГ/

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Хандив өгсөн хуупийн этгээдийн мэдээлэл					Хандив хүлээн авсан			Мөнгөн дүн	Тайлбар	
		Регистрийн дугаар	Хаяг, утасны дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Үйл ажиллагааны чиглэл	Хуулийн этгээдийн хэлбэр	Огноо	Банкны нэр	Дансны дугаар			
Эзлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон												
1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	жилжүүлэх
2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	←
Эзлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд												
1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	←
2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	←

Санамж: Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй.



Тамга, тэмдэг
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
УЯНГА СҮМЫН
ХОРОО

8488916 XHT1221

/тухайн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга тэмдэээр баталгаажуулна./

Гарын үсэг

Албан тушаал

Б. Батбаяржон

Овог Нэр

Гарын үсэг

Огноо

2020.06.19

Огноо